

VII-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хувилбар-А

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:40 минут

Эхийг анхааралтай уншиж ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.

МИНИЙ АНД “ШАР ШУУРГА”

/Ш.СҮРЭНЖАВЫН ТУХАЙ/

... Сүрэнжавыгаа харлаа. Хоёр өлмийгөөрөө дотогшоо гишгэлсэн, түргэн хөдөлгөөнтэй, дээгүүр харцтай шар, залуу байлаа. ...

... Сүрэнжав хурц сэргэлэн зан, хэлэмгий шаламгайгаараа нөхдөөсөө ялгарч байв. Тэр цагийн оюутны болон нийслэлийн залуусын олон удаагийн цэнгээнт үдэшлэгүүдийг гал дөлтэй шүлгээр хөгжөөн хөтөлж, олны танил болж байлаа. ...

... Найзыгаа харахад хэдийгээр 65 нас хүрсэн ч залуугийн ааг омог, хүч чадал нь хэвээрээ, улам ч эрчимтэй бүтээж туурвиж явна. Энэ бол чухам л сэтгэл ариуслын гэрэл гэгээ мөн биз. Сүүлийн жилүүдэд шүлэг найраглал, баримт туужийн ном, роман хэвлүүлж Монгол улсынхаа тусгаар тогтнолыг ямар тэмцэл, үнэ цэнээр олсныг харуулсан кино хийж байна. /... “Урам хайрласан үгс” Пүрэвжавын Пүрэвсүрэн /

1. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олно уу.

/2 оноо/

A. Сүрэнжав хурц сэргэлэн зан, хэлэмгий шаламгайгаараа нөхдөөсөө ялгарч байв.

B. Ш. Сүрэнжавын уран бүтээл болон түүний тухай

C. Сүрэнжавын шүлэг, найраглалын тухай

D. Монгол улсынхаа тусгаар тогтнолыг ямар тэмцэл, үнэ цэнээр олсныг харуулсан кино хийж байна.

2.Гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой.

/2 оноо/

A.Аргал түүхийн жаргалыг яахан мэднэ.

B. Аргалчин аргал түүв.

C. Хүүхдүүд аргалд явдаг.

D. Олон хүүхэд дүрслэгдэв.

3. Сүрэнжав хурц сэргэлэн зан, **хэлэмгий шаламгайгаараа** нөхдөөсөө ялгарч байв

Онцолсон үгийн утгыг олоорой.

2

оноо/

A. Шулуухан зантай

B. Хурдан шаламгай

C. Түргэн ууртай

D.Хэлэх ярихдаа

сурамгай

4. Дараах үгийг бүтээврээр задлан зөв бичих дүрмийг тайлбарлана уу.

/2 оноо/

Авчихъя.....

.....
.....
.....

5. Дараах үгэнд тохирох зөв бичгийн дүрмийг дугуйлна уу?

Хорьё, барья

А. “Ь” тэмдгийн араас “Я, Ё” туслах эгшиг орвол зөөлний тэмдэг “И” болохгүй.

В. “Ь” тэмдгийн араас “Я, Ё” туслах эгшиг орвол зөөлний тэмдэг “И” болно.

С. Хоёр үгээс бүтсэн эхний үг нь “Ь” тэмдгээр төгссөн байвал “И” болно.

Д. Хоёр үгээс бүтсэн эхний үг нь “Ь” тэмдгээр төгссөн байвал “И” болохгүй.

6. Зөв харгалзуулаарай /5 оноо/


1. Шүхэрч Буनिया туурь А. Г.Мэнд-Ооёо

2. Цагаан сүүний домог В. Ц.Түмэнбаяр

3. Хуучин хүү өгүүллэй С. Д.Нацагдорж

4. Нутаг гүйсэн унаганы дууль Д. Б.Ринчен

7. Үндэсний бичгийг бичсэн эхийг кирилл бичигт зөв буулгаарай. /5 оноо/



VII-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хувилбар-В

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:40 минут

Манжаа

Навсгар жаахан Манжаа элбэгдсэн дээл томдсон гуталтайгаа зогсож баих нь модоор зормон монгол шатрын ноёнхорхуу бас ч хэвлүү...

Манжаа нээрээ л буузгар хүн юм. Хонины муухан мөлжсөн тойгордуу хоовон толгойтой, үсээ ямагт тонгоргоор үргээлгэж, нэг талын шазуураа зууж ярих тул ээзгй үмхчихсэн юм шиг нэг хацар нь бумбайж, буузгар дээрээ буузайгаад, ярих гэж удаан зуурч өгнө дөө.

Манжаагийн уг нэр нь Манал. Гэвч миний мэдэхийн л толгойтой болгон Манжаа Манжаа гэгцгээдэг байлаа. Хүүхдээс өндөргүй, өөрөө томдсон ээтэн монгол гутал, элбэгдсэн дээлтэй Манжаа минь.Дээр нь нэг онцлог түүнд байжээ, одоо бодоход. Хүн бүр тэр үед “бидний монгол эзэн Чингисийн үеэс эхлээд...” гэж хэлж байсангүй. Манжаа л хэлнэ. Айл саахалтын адууны хөвгүүд , хурга тугалаас хэтрээгүй муусайн дудрай хүүхдийгч залуу юм, бага юм гэж чамлахгүй, өглөөний адуу оройтуулах, хурга нийлүүлэх зурагт “ манай монгол эзэн Чингисийн үеэс малаа малласаар илэн байтал чи яасан..... “ энэ тэр гэх мэтээр загнаж дуулна.

1. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олно уу? /2оноо/
 - A. Навсгар жаахан Манжаа элбэгдэн дээл томдсон гуталтайгаа зогсож баих нь модоор зормон монгол шатрын ноёнхорхуу бас ч хэвлүү...
 - B. Гэвч миний мэдэхийн л толгойтой болгон Манжаа Манжаа гэгцгээдэг байлаа.
 - C. Хүн бүр тэр үед “бидний монгол эзэн Чингисийн үеэс эхлээд...” гэж хэлж байсангүй. Манжаа л хэлнэ
 - D. Айл саахалтын адууны хөвгүүд , хурга тугалаас хэтрээгүй муусайн дудрай хүүхдийгч залуу юм, бага юм гэж чамлахгүй, өглөөний адуу оройтуулах, хурга нийлүүлэх зурагт “ манай монгол эзэн Чингисийн үеэс малаа малласаар илэн байтал чи яасан..... “ энэ тэр гэх мэтээр загнаж дуулна.
2. Гурван бүрэлдэхүүнт өгүүлбэрийг зөв сонгоно уу? /2 оноо/
 - A. Ард олныг гийгүүлдэг
 - B. Бат ирэв
 - C. Ном уншив.
 - D. Би цүнх авав.
3. “Навсгар жаахан Манжаа **элбэгдсэн** дээл томдсон гуталтайгаа зогсож баих нь модоор зормон монгол шатрын ноёнхорхуу бас ч хэвлүү...” Онцолсон үгийн утгыг тайлбарлана уу?
 - A. Багадсан
 - B. Их олон
 - C. Томдсон
 - D. Хүрэлцээ бага
4. Дараах үгийг бүтээврээр задлан зөв бичих дүрмийг тайлбарлана уу.

Хониор.....
.....

5. Дараах үгэнд тохирох зөв бичгийн дүрмийг дугуйлна уу? /2 оноо/

Нутгийг, Хургаар

А."И"-гээс бусад эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар, нөхцөл залгахад үгийн эцсийн балархай эгшиг гээгдэнэ.

В. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн дагавар, нөхцөл залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг үүрэггүй бол гээгдэнэ.

С. И"-гээс бусад эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар, нөхцөл залгахад үгийн эцсийн балархай эгшиг гээгдэнэ.

Д. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгчээр эгшгээр эхэлсэн дагавар, нөхцөл залгахад өмнө нь эгшиг жийрэглэвэл эцсийн гийгүүлэгчийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ.

6. Зохиолын хэсэглэлийг зөв харгалзуулаарай. /5 оноо/

1. "Ширэлдсэн хар гээгний сэрвийсэн хэдэн үс нь шанаа уруу нь унжина.

А.Шүхэрч Буनिया

2.Хүү ч аавыгаа баярлуулж байхын тулд мэрийсээр арав төгсөхөд хэдэн сар үлдээд байгаа нь

В.Хуучин хүү


3.Хөөрхий өнчин амьтан шогшсоор л байлаа дууль

С.Нутаг гүйсэн унаганы

4.Өршөө намайг. Ах дүү нарынхаа цусыг урсгасан Аян дайны явдалд алжаан сульдлаа би.

Д.Бурхан богд аав хоёр

7. Үндэсний бичгийг бичсэн эхийг кирилл бичигт зөв буулгаарай. /5 оноо/



VII-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хувилбар-С

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:40 минут

Хавар

Гол горхи хүсэл мэт тэмүүлэн урсана. Цэцэг ногоо бодол мэт чимээгүй ургана. Тунгалаг гэрэл, ариун үнэр арван зүгт дэлгэрнэ. Дуу чимээ алслан түгж,цэнхэр, ногоон хоёр өнгө хослон жигдэрнэ. Салхи урьхнаар мяралзан ирж, уйтгарыг аван одно.

Хүний зүрхэнд баяр гийж, хүлгийн туурайнаас ногоон хоёр ханхлахад хэрээ хүртэл сөөнгө хоолойгоор хаврын дуу дуулна.

Гэнэт гэнэт яав, юу болов гэмээр салхи догшрон ирж, согтуу хүн шиг хаалга цонх балбана. Хөрст дэлхий хөх тэнгэр гарчхав уу, гэмээр орчлон ертөнц булингартан эргэлдэж, од гараг мөргөлдөн унах шиг болно. Тэгснээ орой тийшээ ургамал ногоо дэлгэрч байгаа юм шиг нам гүм байтал дахиад л галзуу ганганана.... Хавар би аз жаргалтай гэж өөрийгөө бодно. Хаврын тэнгэр голдуу л хүүхнүүдийн нүд шиг тунгалаг байна. Цагийн цагт тэнгэр хүүхдийн нүд шиг багаасай гэж би хавар улам ихээр хүснэ.

1. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхоолоорой. /2 оноо/

- A. Хүний бодлын тухай
- B. Харын тэнгэрт тогтворгүй ч жаргалтай байдаг тухай
- C. Хавар өөрийгөө жаргалтай гэж боддог тухай
- D. Хаврын тэнгэр голдуу тунгалаг тухай

2. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой.

- A. Хүмүүс шаагьж байлаа.
- B. Би тэмээгээ хураав.
- C. Би хурга буцаав
- D.Би хурганы хойноос цогив

3. Доор өгөгдсөн өгүүлбэрт байгаа тодруулсан үг ямар үүргээр орсон байгааг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу. /2 оноо/

Хөрст дэлхий хөх тэнгэр гарчхав уу, гэмээр орчлон ертөнц **булингартан** эргэлдэж, од гараг мөргөлдөн унах шиг болно.

- A.Алиаа зүйл бохирдох үйл
- B. Толбо болох үйл
- C.Муу муухай болох
- D. Эвдэрч гэмтэх

4. Дараах утгат тохирох зөв үгийг олоорой. /2 оноо/

Зөөлөрсөн тэмдгээр төгссөн үгэнд эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгавал зөөлний тэмдэг “И” болно.

- A. Сахь
- B. Хонь
- C. Барь
- D.Харь

5. Дараах үгэнд тохирох зөв бичгийн дүрмийг дугуйлна уу? /2оноо/

Хүлэхээр

A. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйтэхэд хүрвэл

B. Оноосон нэрийн балархай эгшгийг гээхгүй.

C. үйл үгийн тодотгон холбох “Х”-ийн өмнөх балархай эгшгийг гээхгүй.

D. үйл үгийн тодотгон холбох “Х”-ийн өмнөх балархай эгшгийг гээнэ

6. Зохиолын хэсэглэлүүдийг зөв холбоорой. /5 оноо/

1. Тэгтэл есөн цагаан хун, хун хувцсаа сэлгэж,
есөн сайхан дагина болоод нуурт шунгаж,
дуулж, бөөлж, цэнгэж байжээ.

A. Мэргэн Жа Гүний түүхэн домог

2. Монгол хүн малаа иддэг юм гэж хэлээд
түүхэн домог

B. Хори Түмэд, Хоридай мэргэний

эмээлийг нь авч тавиад дотроос нь халуун
хоол гаргаж ирээд, идэж суужээ.

3. “Огтор сэцэн гүн” хэмээн алдаршсан
нь


C. Халхын дөрвөн хан цол авсан

Улсад туслагч гүн Равдандорж засаг ноён зэрэг залгажээ.

4. Арвай толгой гэх болсон гэнэ. Эдгээр
газар Өвөрхангай аймгийн төвийн орчим
тарагт сумын нутагт бий.

D. Арвайхээрийн түүхэн домог

7. Дараах өгүүлбэрийг зөв хөрвүүлэн бичсэн хэсгийг олоорой. /5 оноо/



7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар-D

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:40 минут

НЭГДҮГЭЭР ДААЛГАВАР

Ай даа зун цаг

Нар цэцэгсийн тэргүүнийг бүлээн цацрагаар илбэн өдөржин урд уулын орой дээр өнжинө. Ойн цоорхойд цоохор янзагаа дагуулсан бугын сүрэг идээшилж, боловсорч гүйцээгүй жимсний ногоон үрэлнүүд эрт хол цагийн анхилам үнэрийг тээн хөвчөөр нэг түгээнэ. Голио царцаахайн исгэчээн шаргиан түмэн хэлийн шувуудын жиргээн дунд хөг аялгуу нэмэн зун цагийг зугаацуулна.

Төд удалгүй аягын чинээ бараан үүл салхи хормойлон ирээд ганц нэгхэн дуслараа борог өвс норгож эхэлнэ. Төд удалгүй бороо гэнэтхэн асгана. Аягын чинээхэн үүлнээс аадрын их хур буух нь соньхон хэрнээ сүрдмээр. Тэрүүхэн хөндий үзүүр шүргээд өнгөрсөн ч гэлээ аянга цахилгаан гялбалзуулна. Их хотын зун ажин түжин. Шил толь болсон өвлийн дүнсгэр хотыг ногоолин эрдэнэс луугаа адил гацуур, улиас, зүлэг, ширэг төгөлдөржүүлэн амилуулжээ. Хөнгөн хөгжмийн аяс онгорхой цонхоор нисэлдэж хүүхэд багачуул усан оргилуур дотор хөгжилдөн өдрийг барна. Хөдөө тийш чиглэсэн нүүдэлчин хотынхон эзгүйрсэн ч гэлээ зуны гоёлоо хот тэр дорхноо олжээ.

Их хотын зун цаг гэж цаанаа өөрийн гэсэн өнгө төрхтэй. Бөгчим халуунд нь амралтаа аваагүй хэсэг нь өглөөнөөс орой хүртэл гудамж талбай дүүргэн зөрөлдөх. Бүгд л яаруу адгуу. Орой болохоор л хотын хэмнэл тэр чигээрээ өөрчлөгдөн дуу хуур, бүжиг наадам зугаа цэнгэлээр дүүрнэ. Хаа л бол хаа инээж хөхөрсөн дуулж хуурдсан хүүхэд багацуул, залуус. Хайрын шивнээ хэлхэн залуу хосууд цэцэрлэгт гудамж чимэн алхана. Доргио залуус рок, поп, транс хөгжим хангинуулан бүжнэ. Их хотын дасал болсон машин тэрэгний дуу чимээ, нүргэлсэн өвлийн чимээ огт үгүй. Нүүрсний утаа, бухимдсан олны жагсаал цуглаан, хөмсөг атируулсан хүмүүс хаашаа ч юм ор сураггүй алга болчихно.

Урт удаан хахир сэрүүн дундах Монгол диваажин зун.

Л.Нарантөгс

Эхийг уншаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй. /2 оноо/

1. Эхийн сэдвийг олоорой. \ 2оноо\

А. Зуны улирлын тухай

В. Их хотын тухай

С Зугаатай үе

Д.Аз жаргалын тухай

2."Араг оосорлосон оёмол дээсний мөрөнд шигдсэн хөндүүр өөрөө арилдаг билээ." Онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ? 2 оноо

А. Өгүүлэгдэхүүн

В. Өгүүлэхүүн

С. Шууд тусагдахуун

Д. Хамжсан

3. Аягын чинээхэн үүлнээс аадрын их хур буух нь **соньхон** хэрнээ сүрдмээр. Онцолсон үгийн утгыг тайлбарлана уу? . /2 оноо/

А.Нилээн сонин

В. Сониуч зан

С.Сүрдмээр

Д.Гайхалтай

4.Дараах үгийг бүтээврээр задлан зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Бодъё.....
.....
.....
.....

5. Дараах үгэнд тохирох зөв бичгийн дүрмийг дугуйлна уу? . /2 оноо/

Цоожийн, багшийг.

A. Эр үгийн эхэнд “Ж, Ч, Ш”-ийн дараа а,о,у эгшиг бичнэ.

B. Эм үгийн эхэнд “Ж, Ч, Ш”-ийн дараа и,ө,ү эгшиг бичнэ.

C. “Ж,Ч,Ш”-ээр төгссөн үгэнд харьяалахын тийн ялгалын “-ийн” заахын тийн ялгалын “ийг” нөхцөл залгана.

D. “Ж,Ч,Ш”-ээр төгссөн үгэнд харьяалахын тийн ялгалын “-ийн” заахын тийн ялгалын “ийг” нөхцөл залгахгүй.

6.Зөв тохируулаарай. . /5 оноо/

1. Ерөөл

A. Зохиолын баатруудын амьдралын нэгэн онцгой чухал үеийн тухай өгүүлдэг үргэлжилсэн үгийн зохиол

2. Магтаал

B. Аливаа үйл явдалд сайн сайхныг хүсэж, баяр наадамд билэгтэй үгийг хэлнэ.


3. Туурь

C. Аливаа сайн сайхан шинж чанарыг сайшаах

4.Өгүүллэг

D. Уран тайлалтай, бүтцийн хувьд хураангуй.

7. Монгол бичгээр бичсэн эхийг уншаад кирилл бичигт буулгаарай. /5 оноо/



VII АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛЭЭР АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар-Е

Сурагчийн нэр..... Анги..... Хугацаа:40 минут

Эхийг анхааралтай уншиж ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.

Сэтгэлийн толин доторх Шаравын Сүрэнжав

...Бурханлаг, сайхан сэтгэлт, эмзэг уяхан, авьяасын гал дөл нь үргэлж л бадран гийж явдаг найрагч бүлгээ. Уулзах бүр шинэ уран бүтээлийнхээ тухай ярина. Тэр нь чи юу хийж, туурвиж байна даа гэсэн сануулга болно. Онгод авьяас гэдэг үргэлжийн залуу мөнх байдаг гэдгийг цог жавхлантай найрагчийн сүүлийн үед бичсэн ном зохиол, кино, шүлэг найраг бидэнд баталж байна.

...Сүрэнжав найрагчийн шүлэг, яруу найраг зохиол бүтээл бол худал хуурмагийн харанхуйг нэвтлэн гийгүүлэгч чанараараа бурхны сургаал номлолтой эн тэнцүү ажгуу.. ...Хавраар, цасны сэмдэс хайлуулан ургах яргуйтай хамт хамгийн түрүүн сэрэгч, намраар, жаврын үзүүрт далавч юугаа холгон буцах тогоруудтай хамт хамгийн түрүүн гунигч тэрбээр “байгалийн нэгэн уяхан ятга” билээ...

/... “Урам хайрласан үгс” Пүрэвжавын Пүрэвсүрэн /

1. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн хэсгийг олно уу.

/2 оноо/

А. Бурханлаг, сайхан сэтгэлт, эмзэг уяхан, авьяасын гал дөл нь үргэлж л бадран гийж явдаг найрагч бүлгээ.

Б. Ш.Сүрэнжавын уран бүтээл болон түүний тухай

В. Онгод авьяас гэдэг үргэлжийн залуу мөнх байдаг гэдгийг цог жавхлантай найрагчийн сүүлийн үед бичсэн ном зохиол, кино ший, шүлэг найраг бидэнд баталж байна.

Г. Уулзах бүр шинэ уран бүтээлийнхээ тухай ярина.

2.”Шувууны үүрэн дээр **сүүдрээ** тусгаж болдоггүй юм шүү”. Онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ? /2 оноо/

А. Шууд тусагдахуун В.Шууд бус тусагдахуун С. Хамжсан тодотгол D. Өгүүлэхүүн

3...”Бурханлаг, сайхан сэтгэлт, эмзэг уяхан, авьяасын **гал дөл** нь үргэлж л бадран гийж явдаг найрагч бүлгээ” онцолсон үгийн утгыг олоорой . /2 оноо/

А. Сайхан сэтгэлтэй В. Залуу насны ааг омгоор

С. Өөдөө бадрах D. Ширүүн сүртэй

4. Дараах үгийг бүтээврээр задлан зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Бодъё.....
.....
.....
.....
.....

5. Дараах үгэнд тохирох зөв бичгийн дүрмийг дугуйлна уу? . /2 оноо/

Гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-Л” дагаврыг залгахад балархай эгшгийг хойно нь бичих үг аль нь вэ?

A. Цонх B. Борц C. Алдал D. Хэрэглэ

6. “Мэддэгт мэргэн цоохор

Мэддэггүйд эрээн цоохор” хэмээх санааг илэрхийлэх зохиол аль нь вэ? Зөвийг сонгоорой. . /5 оноо/

A. Л. Түдэв “Эрээн цоохор” туурь

B. Б. Ринчен “Шүхэрч Буनिया”

C. Ц. Түмэнбаяр “Цагаан сүүний домог” туурь

D. П. Пүрэвсүрэн “Бурханбогд аав хоёр” өгүүллэг

7. Монгол бичгээр бичсэн эхийг уншаад кирилл бичигт буулгаарай. /5 оноо/

ᠨᠠᠯᠠᠳᠤ ᠠᠯᠠᠳᠤ
ᠨᠠᠯᠠᠳᠤ ᠠᠯᠠᠳᠤ
ᠨᠠᠯᠠᠳᠤ ᠠᠯᠠᠳᠤ

ШИНЭ ХӨГЖИЛ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 7-АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ”
ХИЧЭЭЛИЙН НЭГДМЭЛ АГУУЛГЫН ЗӨВ ХАРИУЛТ

А-Хувилбар	В хувилбар	С-Хувилбар	Д хувилбар	Е хувилбар
1-В	1-Д	1-В	1-В	1-В
2-В	2-В	2-А	2-А	2-А
3-Д	3-С	3-А	3-А	3-С
4. сурагч тайлбарлах	4. Сурагч тайлбарлах	4. Сурагч тайлбарлах	4. Сурагч тайлбарлах	4. Сурагч тайлбарлах
5- А	5-В	5-С	5-С	5-Д
6. 1-Д 2-В 3-С 4-А	6. 1-В 2-Д 3-С 4-А	6.1-В 2-С 3-А 4-Д	6.1- В 2 -С 3 -А 4-Д	6-А
7. Яснаас шүд Махнаас нүд Явсан нохой яс зууна. Хэвтсэн хүн алдана.	7. Эрт урьд цаг дор нэгэн хүн ой дотор явж байгаад нэгэн хуш модны дэргэд очоод	7. Баяр эсэргэ талынхаа хаалгаруу бөмбөг оруулахаар хөөж явлаа.	7.Айл өрх бүр гэртээ морин хууртай байхыг эрхэмлэдэг.	7.Нэг нь хоёр хар, нөгөө нь хоёр цагаан хүүгээр тоглоно.